



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 4/50

Жавхлант

**Бие бялдарын түвшин тогтоох сорил авах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ерөнхийлөгчийн 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 53 дугаар зарлиг, "Биеийн тамир, спортын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорилыг 3-64 насны иргэдээс авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ариунболд

Нарийн бичгийн дарга:

Э.Хонгорзул

Гишүүдэд:

Х.Энх-Уянга

Ж.Төртогтох

Г.Хүрэлбаатар

С.Отгонбаяр

Ө.Золзодмаа

Г.Ариунтунгалаг

Г.Энхцолмон

Н.Эрдэнэзаяа

ЕБС-ийн Биеийн тамирын багш

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Дэлгэрхаан багийн Засаг дарга

Наран багийн Засаг дарга

Сүмбэр багийн Засаг дарга

Жавхлант багийн Засаг дарга

ЕБС-ийн эрүүл мэндийн багш

Нийгмийн эрүүл мэндийн эмч

Цэцэрлэгийн багш

Соёлын төвийн бүжгийн багш

2. Бие бялдарын түвшин тогтоох сорилд багийн иргэдийг идэвхтэй хамруулахыг Багийн Засаг дарга нарт, ажилтан албан хаагчид болон ЕБС, Цэцэрлэгийн хүүхдүүдийг бүрэн хамруулахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт, үүрэг болгосугай.

3. Хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорилыг авч программын дагуу дүн мэдээг нэгтгэн аймгийн Биеийн тамир, спортын газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Ариунболд), Нарийн бичгийн дарга (Э.Хонгорзул) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.БАТЧУЛУУН



D:Zasag darga /zahiramj-2025/